



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2022/104/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Ариунбаяр Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Запруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт .....	13
4.4 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Соёл, 02, 25 № 63  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ  
СУМЫН 3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Д.БОЛОРТУЯА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийг харилцагч байгууллагад шилжүүлж бодит бус авлага үүсгэсэн, үйл ажиллагаанд зарцуулсан материалыг зарлагадаагүй, аж ахуйн материалд үндсэн хөрөнгө бүртгэсэн, шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлээгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн, Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>38,138,047.22</u>	<u>49,262,589.69</u>
33	АВЛАГА	1,031,226.22	574,094.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	574,094.49
335	Бусад авлага	1,031,226.22	00.00
3351	Байгууллагаас авах авлага	1,031,226.22	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37,106,821.00	48,688,495.20
351	Түүхий эд материал	295,550.00	494,120.00
35130	Эм боох материал	295,550.00	494,120.00
354	Хангамжийн материал	36,811,271.00	48,194,375.20
35410	Бичиг хэргийн материал	663,750.00	360,700.00
35420	Аж ахуйн материал	43,280.00	19,470.00
35440	Түлш, шатах тослох материал	149,760.00	00.00
35460	Хүнсний материал	1,240,765.00	741,813.20
35470	Бусад хангамжийн материал	34,713,716.00	47,072,392.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>403,793,498.15</u>	<u>383,470,903.32</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	403,793,498.15	383,470,903.32
392	Биет хөрөнгө	345,809,498.15	325,486,903.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	357,186,904.21	357,186,904.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-29,457,576.00	-49,095,960.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,287,200.00	22,592,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,951,037.21	-11,698,780.69
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,538,152.00	16,098,152.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,808,278.01	-12,633,745.36
39214	Бусад үндсэн хөрөнгө	700,000.00	700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-700,000.00	-700,000.00
39217	Ном	3,014,133.16	3,038,133.16
393	Биет бус хөрөнгө	57,984,000.00	57,984,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	57,984,000.00	57,984,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>441,931,545.37</u>	<u>432,733,493.01</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,156,475.63</u>	<u>684,303.63</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,156,475.63	684,303.63
413	Өглөг	10,156,475.63	684,303.63
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,911,225.63	684,303.63
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	239,780.00	00.00
4136	Бусад өглөг	4,005,470.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	4,005,470.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>431,775,069.74</u>	<u>432,049,189.38</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	431,775,069.74	432,049,189.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	189,364,077.15	189,364,077.15
51101	Өмч: - төрийн	189,364,077.15	189,364,077.15
512	Хуримтлагдсан үр дүн	-136,625,453.86	-136,351,334.22
51210	Өмнөх үеийн үр дүн	-136,625,453.86	-137,043,463.86
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	692,129.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	379,036,446.45	379,036,446.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>441,931,545.37</u>	<u>432,733,493.01</u>

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	473,327,200.00	528,187,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,445,400.00	92,277,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	8,457,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,457,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	8,457,000.00
122	Тусламжийн орлого	4,609,000.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	4,609,000.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	79,836,400.00	83,820,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	79,836,400.00	83,820,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,800,000.00	5,300,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,081,800.00	430,609,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,800,000.00	5,300,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,300,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	489,264,620.92	527,495,370.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,776,309.09	527,495,370.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,488,428.64	525,398,335.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	302,261,887.00	330,044,745.74
210101	Үндсэн цалин	266,157,730.00	249,534,184.40
210102	Нэмэгдэл	6,991,646.00	54,738,896.83
210104	Урамшуулал	29,112,511.00	25,771,664.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,684,817.54	42,711,947.28
210201	Тэтгэврийн даатгал	27,222,649.38	32,016,805.31
210202	Тэтгэмжийн даатгал	2,639,767.96	2,673,785.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,518,207.72	2,139,028.35
210204	Ажилгүйдлийн даатгал	573,108.41	534,757.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,731,084.08	5,347,571.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,570,941.00	79,585,345.53
210301	Гэрэл, цахилгаан	2,203,551.00	3,843,989.53
210302	Түлш, халаалт	63,391,790.00	67,919,775.00
210303	Цэвэр, бохир ус	8,975,600.00	7,821,581.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,611,570.00	5,280,923.00
210401	Бичиг хэрэг	1,131,600.00	3,014,450.00
210402	Тээвэр, шатахуун	620,060.00	487,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	536,150.00	220,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,323,760.00	1,558,013.00
2105	Нормативт зардал	31,127,310.00	28,371,458.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,310,062.00	1,902,676.00
210502	Хоол, хүнс	17,655,980.00	25,855,892.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,161,268.00	612,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,277,494.78	5,535,420.00
210602	Тавилга	1,854,014.78	00.00

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар	6,423,480.00	5,535,420.00
2107	Томилолт, зочны зардал	157,500.00	117,000.00
210702	Дотоод албан томилолт	157,500.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	298,087.00	8,843,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	298,087.00	8,843,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,498,821.32	24,907,594.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	321,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,253,995.00	375,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,244,826.32	24,211,594.83
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,287,880.45	2,097,035.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,782,641.45	1,740,260.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,782,641.45	1,740,260.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,505,239.00	356,774.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,505,239.00	356,774.47
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	488,311.83	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	488,311.83	00.00
222001	Тоног төхөөрөмж	488,311.83	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-15,937,420.92</u>	<u>692,129.64</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-15,937,420.92</u>	<u>692,129.64</u>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.45	-136,625,453.86	431,775,069.74
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.45	-136,625,453.86	431,775,069.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-418,010.00	-418,010.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.45	-137,043,463.86	431,357,059.74
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	692,129.64	692,129.64
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	189,364,077.15	379,036,446.45	-136,351,334.22	432,049,189.38

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	470,157,029.00	519,730,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,836,400.00	83,820,900.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	79,836,400.00	83,820,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	79,836,400.00	83,820,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	390,320,629.00	435,909,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	386,081,800.00	430,609,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,238,829.00	5,300,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,438,829.00	5,300,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	470,157,029.00	519,706,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,157,029.00	519,706,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,869,148.55	517,609,464.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	302,925,762.55	335,326,967.74
210101	Үндсэн цалин	211,171,662.53	252,580,662.04
210102	Нэмэгдэл	54,533,556.41	57,509,585.05
210104	Урамшуулал	37,220,543.61	25,236,720.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,686,100.00	43,254,815.55
210201	Тэтгэврийн даатгал	25,626,500.00	30,008,456.83
210202	Тэтгэмжийн даатгал	3,014,900.00	3,311,589.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,411,900.00	2,649,271.71
210204	Ажилгүйдлийн даатгал	603,000.00	662,317.94
210205	Эрүүл мэндийн даатгал	6,029,800.00	6,623,179.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,331,161.00	80,464,125.53
210301	Гэрэл, цахилгаан	2,203,551.00	4,371,989.53
210302	Түлш, халаалт	63,391,910.00	69,730,736.00
210303	Цэвэр, бохир ус	8,735,700.00	6,361,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,876,315.00	4,424,400.00
210401	Бичиг хэрэг	943,845.00	511,600.00
210402	Тээвэр, шатахуун	749,820.00	180,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	446,150.00	220,500.00
210404	Ном, хэвлэл	87,100.00	66,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,649,400.00	3,445,900.00
2105	Нормативт зардал	23,744,610.00	27,694,741.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,066,502.00	738,600.00
210502	Хоол, хүнс	17,230,608.00	25,269,441.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,447,500.00	1,686,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,800,000.00	9,663,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,800,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	9,663,900.00
2107	Томилолт, зочны зардал	157,500.00	117,000.00

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	157,500.00	117,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	278,000.00	12,891,215.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	278,000.00	12,891,215.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,069,700.00	3,772,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,182,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,069,700.00	2,590,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,287,880.45	2,097,035.18
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,782,641.45	1,740,260.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,782,641.45	1,740,260.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,505,239.00	356,774.47
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,505,239.00	356,774.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	24,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	00.00	24,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	24,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	24,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	24,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-24,000.00

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	524,430,500.00	511,805,464.82	12,625,035.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	524,430,500.00	511,805,464.82	12,625,035.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	524,430,500.00	511,805,464.82	12,625,035.18
2101	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	335,388,700.00	335,326,967.74	61,732.26
210101	Үндсэн цалин	257,868,400.00	252,580,662.04	5,287,737.96
210102	Нэмэгдэл	52,853,700.00	57,509,585.05	-4,655,885.05
210104	Урамшуулал	24,666,600.00	25,236,720.65	-570,120.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,925,900.00	43,254,815.55	1,671,084.45
210201	Тэтгэврийн даатгал	33,066,400.00	30,008,456.83	3,057,943.17
210202	Тэтгэмжийн даатгал	2,964,800.00	3,311,589.68	-346,789.68
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,371,900.00	2,649,271.71	-277,371.71
210204	Ажилгүйдлийн даатгал	593,000.00	662,317.94	-69,317.94
210205	Эрүүл мэндийн даатгал	5,929,800.00	6,623,179.39	-693,379.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,820,900.00	79,936,125.53	10,884,774.47
210301	Гэрэл, цахилгаан	9,708,700.00	3,843,989.53	5,864,710.47
210302	Түлш, халаалт	74,350,800.00	69,730,736.00	4,620,064.00
210303	Цэвэр, бохир ус	6,761,400.00	6,361,400.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,348,400.00	2,348,400.00	0.00
210401	Бичиг хэрэг	511,600.00	511,600.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	180,000.00	180,000.00	0.00

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэт төлбөр	220,500.00	220,500.00	0.00
210404	Ном, хэвлэл	90,400.00	90,400.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,345,900.00	1,345,900.00	0.00
2105	Нормативт зардал	27,514,800.00	27,514,741.00	59.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	558,600.00	558,600.00	0.00
210502	Хоол, хүнс	25,269,500.00	25,269,441.00	59.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,686,700.00	1,686,700.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,544,000.00	8,543,900.00	100.00
210604	Урсгал засвар	8,544,000.00	8,543,900.00	100.00
2107	Томиллолт, зочны зардал	117,000.00	117,000.00	0.00
210702	Дотоод албан томиллолт	117,000.00	117,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,998,500.00	10,991,215.00	7,285.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,998,500.00	10,991,215.00	7,285.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3772300.00	3772300.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,182,000.00	1,182,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэл дадлага хийх	2,590,300.00	2,590,300.00	0.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>430,609,600.00</b>	<b>428,869,339.29</b>	<b>1,740,260.71</b>
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>430,609,600.00</b>	<b>428,869,339.29</b>	<b>1,740,260.71</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	430,609,600.00	428,869,339.29	1,740,260.71
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>93,820,900.00</b>	<b>83,464,125.33</b>	<b>10,356,774.67</b>

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		5,300,000.00	-5300000.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		5,300,000.00	-5300000.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		5,300,000.00	-5300000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		2,100,000.00	-2100000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,100,000.00	-2100000.00
2105	Нормативт зардал		180,000.00	-180000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		180,000.00	-180000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,120,000.00	-1120000.00
210604	Урсгал засвар		1,120,000.00	-1120000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,900,000.00	-1900000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,900,000.00	-1900000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		5300000.00	-5300000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		5,300,000.00	-5300000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,300,000.00	-5300000.00

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

#### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 490,135.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,901.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар 3,430.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,198.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Авлага	-	574.1	574.1
Бараа материал	37,106.8	48,688.5	11,581.7
Үндсэн хөрөнгө	403,793.5	383,470.9	(20,322.6)
Нийт хөрөнгө	441,931.5	432,733.5	(9,180.0)
Өр төлбөр	10,156.5	684.3	(9,472.2)
Засгийн газрын хувь оролцоо	431,775.1	432,049.2	274.1
Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	441,931.5	432,733.5	(9,180.0)

- Тайлант онд цалин сангаас хэмнэгдсэн 574.1 мянган төгрөгийг татварын хэлтэст шилжүүлж авлагаар бүртгээсэн байна.
- Бараа материал данс өмнөх оноос 11,581.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 50,739.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 4,592.0 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 43,750.0 мянган төгрөгийн материал зарцуулсан бөгөөд аж ахуйн зориулалттай материал худалдан авч үлдээгдлээр тайлагнасан нь бараа материал дансны үлдэгдэл нэмэгдэхэд нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс өмнөх оноос 20,322.6 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгө өмнөх оноос буурсан нь 24,9047.6 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл бодуулж данснаас үнийг хасагдуулсан нь нөлөөлжээ. Тайлант онд дээд шатны төсөв захирагчаас үнэ төлбөргүйгээр 3,865.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.
- Өр төлбөр өмнөх оноос 9,472.2 мянган төгрөгөөр буурсан. Энэ нь тайланд онд урсгал засвартай холбогдуулан гарсан өр төлбөрийг барагдуулж, шинээр өр төлбөр үүсгээгүй нь нөлөөлж байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 430,609,6 мянга, орон нутгийн төсвөөс 93,820.9 мянга нийт 524,430.5 мянган төгрөгийг төлөвлөж, улсын төсвөөс 430,609.6 мянга, орон нутгийн төсвөөс 83,820.9 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт

зарлагыг 511,805.5 мянган төгрөгөөр илэрхийлж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 2,097.1 мянган төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн дансанд төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 380,678.8 мянган төгрөг буюу 74.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл эзэлж байгаа бол 131,126.7 мянган төгрөг буюу 25.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал зэрэг бусад зардлууд эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.2 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Баруун-Урт сумын 3 дугаар цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар 5,300.0 мянган төгрөг төвлөрч, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад 180.0 мянга, багаж, техник хэрэгсэл худалдан авахад 2100.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрийн хураамжид 1,900.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 зорилтын хүрээнд 86 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 91.2 хувьтай тайлагнасан бөгөөд зарим төлөвлөсөн арга хэмжээг ковид цар тахлын улмаас хэрэгжүүлээгүй байна.

2021 оны эхний хагас жилд танхимаар хичээллээгүй бөгөөд цахим сургалтад 249 хүүхэд хамрагдахаас 217 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 90 хувьтай байна. Сүүлийн хагас жилд танхимаар 152 хүүхэд хамрагдахаас 130 хүүхэд хамрагдаж хамран сургалт 85.5 хувь, цахимаар буюу теле сургалтад 72 хүүхэд хамрагдахаас 64 хүүхэд хамрагдаж 88.8 хувьтай байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус цэцэрлэг нь цалингийн сан хүрэлцээгүй гэх шалтгаанаар ажилчдын 3 дугаар улирлын үр дүнгийн урамшууллыг олгоогүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 135 мэдээллийг хугацаанд нь 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4 зарлагын гүйлгээний 50,038.8 мянга, урсгал санхүүжилтийн 25 гүйлгээний 504.299.9 мянга, өр төлбөрийн 684.3 мянга, авлагын 574.1 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,402.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 10,156.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, дотоод хяналт, шилэн дансны мэдээлэл болон бараа материалын данстай холбоотой 3 зөвлөмж хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг 2021 оны 23 тоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн боловч шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх талаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 14,955.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,581.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 574.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 12,799.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

### **4.1 Залруулсан алдаа**

*1. Авлагыг эхний үлдэгдэл 1,000.0 мянган төгрөг төлөгдсөнийг мөнгөн хөрөнгө болон үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардалд илэрхийлснийг өмнөх үеийн үр дүнд залруулав;*

*2. Өглөгийн эхний үлдэгдэл 581.9 мянган төгрөгийг төлж барагдуулсан боловч санхүүгийн тайланд үлдэгдлээр илэрхийлснийг залруулав;*

### **4.2 Төлбөрийн акт**

*Цалингийн төсвөөс хэмнэгдсэн 574.1 мянган төгрөгийн үлдэгдлийг татварын хэлтсийн харилцах дансанд шилжүүлж, авлага үүсгэн төсвийн хэмнэгдсэн үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.*

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>1</sup>, 6.4.8<sup>2</sup>, 41 дүгээр зүйлийн 41.2.3<sup>3</sup>, 45 дугаар зүйлийн 45.2<sup>4</sup>, заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо. Энэ нь санхүүгийн тайлангийн болон ажил гүйлгээний иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **4.3 Хариуцлага тооцох албан шаардлага**

Тус цэцэрлэгийн нягтлан бодогч шилэн дансны цахим системд зарим мэдээллийг бүрэн мэдээлээгүй, зарцуулагдсан бараа материалыг санхүүгийн тайланд зарлага болгоогүй, нярвын тайланг хүлээн авч санхүүгийн тайлангийн үлдэгдэлтэй тулгаагүй зэрэг зөрчил дутагдал гаргаж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хангалтгүй хэрэгжүүлж байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1<sup>5</sup>-т заасны дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг төсвийн шууд захирагчид хүргүүлээ.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдсан, цаашид ашиглагдах боломжгүй болсон /гэрийн бүрээс, цаваг, гэрлийн утас, сантехникийн материал гэх мэт/ үндсэн хөрөнгийн данс болон бараа материал дансанд бүртгэлтэй 7,203.0 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадахгүйгээр данс бүртгэлд үлдээдлээр илэрхийлж, санхүүгийн тайлангийн үлдэгдлийг буруу илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх онд зарцуулсан материалыг анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлээс хасаж, үлдэгдлийг үнэн зөв илэрхийлэх;

##### **2. Бараа материалын данс бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бусад хангамжийн материал дансанд 2,596.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байна.

Өгсөн зөвлөмж: Бусад хангамжийн материал дансанд эдийн засгийн ангиллаар буруу бүртгээгдсэн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн бүртгэх;

##### **3. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 41 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

<sup>1</sup> .төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

<sup>2</sup> төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

<sup>3</sup> төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

<sup>4</sup> .Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ;

<sup>5</sup> Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

#### 4. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн сургалтын үйл ажиллагаанд ашиглагдах боломжгүй болсон 3,000.0 мянган төгрөгийн ном, сургалтын материал данс бүртгэлд бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Сургалтын үйл ажиллагаанд ашиглах боломжгүй номыг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр гаргуулж, акталж устган данс бүртгэлээс хасах;

#### 5. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цэцэрлэгийн их засвартай холбоотой шинээр камер суурилуулсан боловч нягтлан бодогч санхүүгийн тайланд орлогоор тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нярвын тайлант орлогоор бүртгээгдсэн камерыг анхан шатны баримтад үндэслэн данс бүртгэлд тусгах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	3 дугаар цэцэрлэг	5	14,955.0	2	1,581.9	1	574.1	1		5	12,799.0
	ДҮН	5	14,955.0	2	1,581.9	1	574.1	1		5	12,799.0